

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН “НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2018.11.05.

<b>№</b>	<b>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа</b>	<b>Хэрэгжилт</b>	<b>Хувь</b>
1	Ажилтнуудад “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг танилцуулах	Ажилтнуудаас санал авч “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны А/15 дугаар тушаалаар батлуулж, ажилтнуудад танилцуулсан.	100
2	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргах	“Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 чиглэл, 22 хэрэгжүүлэх үйл ажиллагаатайгаар батлуулсан, 11 сарын байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 81.8%-тай хэрэгжсэн.	100
3	Ажилчидаас санал, хүсэлт авч төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах	Төлөвлөгөөнд ажилтнуудаас санал ирээгүй.	100
<b>1. Ажиллагсдыг орон сууцаар хангах, нөхцөлийг сайжруулах чиглэлээр</b>			
4	Ажилчдаас орон байрны зээл, төрийн албан хаагчийн хөнгөлөлттэй урт хугацааны зээлийг эхний ээлжинд хамруулах	Хамруулаагүй	0
5	Ажилчдын орон сууцны нөхцөлийн судалгааг тогтмол гаргах	Ажилтнуудын орон сууцны нөхцөлийн судалгааг гаргасан.	100
<b>2. Ажиллах нөхцөл боломжийг сайжруулах чиглэлээр</b>			
6	Ажилтнуудын ажлын үр дүнг тооцож урамшуулал олгох, орон нутгийн болоод салбарын, төрийн дээд шагналд тодорхойлох	Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлыг улирал бүр дүгнэж байна. 3 дугаар улирлын байдлаар үр дүнгийн урамшуулалд нийт 48 хүнд давхардсан тоогоор 9451800 төгрөг төгрөг олгоод байна. Ажлын үр дүнгээр 2017 оны байдлаар ЭМГ-ын даргын “Өргөмжлөл”-өөр УТСХ-ийн дарга Ц.Энхсайхан, нярав Н.Оюунчимэг, бүртгэл мэдээллийн ажилтан Ё.Цэцэг-Өлзий нар шагнагдсан байна. 2018 онд ажлаараа шалгарч ЭМЯ-ны “Хүндэт жуух” бичигээр мэргэжилтэн Б.Ширчмаа, жолооч М.Гармаа, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр мэргэжилтэн Г.Улааннаран, Ч.Мөнхжаргал нар тус тус шагнагдсан байна.	100
7	Ажлын байрны тав тухтай орчин бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг хангаж эмнэлэг бүр “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага “болох хөдөлгөөнийг өрнүүлж ажиллах		0

8	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан сургагч багш бэлтгэх, орон тооны бус албаны үйл ажиллагааг тогтмолжуулах	НДЕГ-ын захиалгаар аймгийн нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран “Нийгмийн даатгалд даатгуулагчийг үйлдвэрлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н сургагч багш бэлтгэх сургалтанд мэргэжилтэн Б.Ширчмааг хамруулсан. <b>Үр дүн:</b> Сургагч багш бэлтгэсэн.	70
9	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалт зохион байгуулах	“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа”-ны чиглэлээр сургагч багш 23 албан хаагчид сургалт зохион байгуулсан.	100
10	Орон сууцны болон цалингийн зээл хөнгөлөлттэй олгуулах боломжийг судалж, шийдвэрлэх	2016 оноос ХААН БАНК-тай хамтран албан хаагчдын цалингийн зээлийн хүүг бууруулан ажиллаж байна.	70
11	Ажилтнуудад баярт үйл явдал болон гачигдал тохиолдох үед байгууллагын дотоод журмын дагуу урамшуулал, буцалтгүй тусламж олгож байх	Ажилтнуудад баярт үйл явдал болон гачигдал тохиолдсон үед ажилтнуудын дундын фондноос тусламж, хандив өгч байна. 2018 оны 11 сарын байдлаар нийт 1155000 төгрөг хуримтлагдахад байна. Үүнээс 22 үйл ажиллагаанд 1010000 төгрөг зарцуулсан байна. 72.78%-ийг тусламж, 9%-ийг шагнал урамшуулал авсан хүнд, 18.1%-ийг нийтийн арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.	100
12	Жил бүр байгууллагын “Аварга ажилтан” шалгаруулж, самбарт зургыг нь тавьж алдаршуулах	Ажлын үр дүнгээр 2017 оны “Байгууллагын аварга ажилтан”-аар цахилгаанчин Б.Гантулга шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.	100
13	Албан хаагчдийн өрхийн орлогыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхийн тулд туслах аж ахуй эрхлэх, ногоо тарихад нь дэмжлэг үзүүлж зохион байгуулалтын арга хэмжээ авч байх		0
14	Цалин хөлс, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар хийгдэж байгаа төсөл хөтөлбөрийн мэдээллийн сан, судалгааг бүрдүүлэх	Цалин хөлс, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар тогтмол судалгаа хийж байна. 2018 оны 10 сард 26 албан хаагчын цалинг нэмсэн.	100
<b>3. Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр</b>			
15	Байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийг хариуцсан эмч томилох	Байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийг хариуцсан эмч томилох талаар ЭМГ-ын даргатай ярилцаж тушаал гаргахаар боллоо.	70
16	Ажилчдыг жилд 1-ээс доошгүй удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Ажилтнуудыг 4 дүгээр улиралд урьдчилан сэргийлэх үзлэгт 1 удаа хамруулсан. Үзлэгт 24 албан хаагч хамрагдсан.	70

17	Эрүүлжүүлэх арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах	Эрүүл мэндийн газрын нийт 25 ажилчдыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “Журам батлах тухай” 19 дүгээр тогтоолын дагуу “Багц урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношлогоо”-нд хамрууллаа. Шинээр ажилд орсон 3 хүнийг В гепатитийн эсрэг дархлаажуулалтанд хамруулсан.	100
<b>4. Ажилчдыг сургаж, мэргэшүүлэх чиглэлээр</b>			
18	Ажилтануудыг гадаадад сургалтанд хамруулах, туршлага судлах танилцах, аялалд явуулах	Глобаль удирдагч дээд сургуультай хамтран Тайвань улсад ЭМГ-ын дарга хамтын хэлэлцээрт гарын үсэг зурах чиглэлээр 7 хоног туршлага судалсан.	40
19	Ажилтнуудыг богино хугацааны сургалтуудад тогтмол хамруулж, багц цагаа биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх	<p><b>Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:</b></p> <p>“НЭМ-ийн тусламж үйлчилгээг сайжруулах-Судалгааны арга зүй” сэдэвт 2 өдрийн сургалтанд орон нутагт НЭМХ-ийн 3 мэргэжилтэнг хамруулсан.</p> <p>“Сэргээн засах, нийгмийн эрүүл мэндийн сургалт” сэдэвт 3 өдрийн сургалтанд аймгийн төвд мэргэжилтэн С.Долгорсүрэнг хамруулсан.</p> <p>“Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн вируст хепатетийн илрүүлэг шинжилгээ хийх арга зүй эзэмшүүлэх сургагч багш бэлтгэх” 3 өдрийн сургалтанд Улаанбаатар хотод НЭМХ-ийн дарга Б.Саруулцэцэг, мэргэжилтэн Б.Ширчмаа нарыг хамруулсан.</p> <p>“Хүн амын хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын өнөөгийн байдал, сайржуулах арга зам” сэдэвт 2 өдрийн сургалтанд улаанбаатар хотод эрүүл мэндийг дамжих сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Г.Содномдаржааг хамруулсан.</p> <p>Этүгэн дээд сургуультай хамтран “Халдварын сэргийлэлт, хяналт” сэдэвт 1 өдрийн сургалтанд Б.Саруулцэцэг, Г.Улааннаран нарыг аймгийн төвд хамруулсан.</p> <p>“Хог хаягдлын менежмент” 1 өдрийн сургалтанд аймгийн төвд Г.Улааннаранг хамруулсан.</p> <p>“НЭМ, Тархвар зүй” сэдэвт 10 хоногийн сургалтанд улаанбаатар хотод Ц.Загдсүрэнг хамруулсан.</p> <p>“Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалт” сэдэвт 1 өдрийн сургалтанд Өмнөговь аймагт Б.Саруулцэцэг, С.Долгорсүрэн, Г.Улааннаран нар хамрагдсан.</p> <p><b>Эмнэлгийн тусламжийн чиглэлээр:</b></p> <p>“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” сэдэвт улсын зөвлөгөөнд ЭМГ-ын дарга Улаанбаатар хотод оролцсон.</p> <p>“Үйлчлүүлэгчдийн биеийн үнэлэх нь” аймгийн төвд болсон 1 өдрийн багц цагийн сургалтанд 5 албан хаагч хамрагдсан байна.</p>	100

		<p>ЭМХТөв, УНТЭ, Гедеон рехтер хамтран зохион байгуулсан “Үрэвслийн эсрэг дааврын бус бэлдмэлийн клиникийн зохистой хэрэглээ” сэдэвт 1 өдрийн сургалтанд улаанбаатар хотод Л.Ганбатыг хамруулсан.</p> <p>“Хүүхдийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт бүсийн зөвлөгөөнд Дорноговь аймагт ЭТХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Нямтогтохыг хамруулсан.</p> <p>Улаанбаатар хотод “Эх нярайн эрүүл мэнд, яаралтай эх барих тусламж” сэдэвт 5 хоногийн сургалтанд ЭТХ-ийн дарга Л.Ганбатыг хамруулсан</p> <p>“Бэлгийн болон НҮЭМ, гэр бүл төлөвлөлт, жирэмсний хяналтын чанар” сэдэвт 2 өдрийн сургалтанд улаанбаатар хотод ЭТХ-ийн дарга Л.Ганбатыг хамруулсан.</p> <p>“Эмнэлгийн бие даасан байдал” сэдэвт 2 өдрийн сургалтанд улаанбаатар хотод Л.Ганбатыг хамруулсан.</p> <p>“Сувилахуйн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал цаашдын чиг хандлага” сэдэвт бүсийн зөвлөгөөнд Дорноговь аймагт П.Оюунчимэгийг хамруулсан.</p> <p>“Цэвэршилтийн үеийн тусламж, үйчилгээг хувь хүний эрүүл мэндийн онцлогт тохируулах нь” 2 өдрийн сургалтанд улаанбаатар хотод ЭТХ-ийн дарга Л.Ганбат хамрагдсан.</p> <p>“Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусгамдсан асуудал-2018” 2 өдрийн улсын зөвлөгөөнд улаанбаатар хотод Ахлах мэргэжилтэн Д.Нямтогтох хамрагдсан.</p> <p>“Эх орны ирээдүй-эрүүл хүүхэд онол практикийн хурал” улаанбаатар хотод эрүүл мэндийн газрын дарга Г.Бат-Орших хамрагдсан.</p> <p>“Монголын яаралтай тусламжийн мэргэжилтнүүдийн үндэсний чуулган-2018” чуулганд улаанбаатар хотод мэргэжилтэн Г.Улааннаран хамрагдав.</p> <p>“Эрүүл насжилт, настны эрүүл мэндийн үндэсний чуулган”-д улаанбаатар хотод ЭМГ-ын дарга Г.Бат-Орших, ахлах мэргэжилтэн Ц.Загдсүрэн нар хамрагдав. <b>Үр дүн:</b> Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмч нарын 2018 оны багц цагийн биелэлт 100% бүрдсэн.</p>	
20	Ажилтнуудыг төгсөлтийн дараах сургалтанд хамруулах	<p>Улсын төвсийн санхүүжилтээр 2018 онд хүүхдийн үндсэн мэргэжлээр Б.Энхсайхан, Лаборторын үндсэн мэргэжлээр Ц.Энхсайхан нар 2 дахь жилдээ суралцаж байна.</p> <p>Батлагдаж ирсэн хуваарийн дагуу эмийн удирдлага, зохион байгуулалт 6 сарын төрөлжсөн мэргэжлийн сургалтанд эмийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Б.Уранбайгаль суралцаж төгссөн.</p>	100

		Батлагдаж ирсэн хуваарийн дагуу эмэгтэйчүүдийн ЭХО-ийн мэргэжил дээшлүүлэх 4 сарын сургалтанд ЭТХ-ийн мэргэжилтэн Д.Нямтогтох хамрагдсан.	
21	Ажилтнуудыг хууль эрх зүй, ёс зүйн сургалтанд хамруулах	<p>ЭМХТөв, Этүгэн дээд сургуультай хамтран “Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг хэм хэмжээ болон харилцааны ур чадвар” сэдэвт орон нутагт болсон 1 өдрийн сургалтанд Л.Ганбат, О.Урансоёл нарыг хамруулсан.</p> <p>ЭМЯамнаас Улаанбаатар хотод зохион байгуулсан “ЭМТусламж, үйлчилгээний чанар, өвчтөний аюулгүй байдал, ёс зүй” сэдэвт улсын зөвлөгөөнд ЭТХ-ийн дарга Л.Ганбат, ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга П.Оюунчимэг нарыг хамруулсан.</p> <p>ЭМХТөвтэй хамтран орон нутагт зохион байгуулсан “Харилцаа хандлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдэвт 2 өдрийн сургалтанд НЭМХ-ийн дарга Б.Саруулцэцэг, мэргэжилтэн С.Долгорсүрэн, Г.Улааннаран нарыг хамруулсан.</p> <p>ЭМЯамнаас зохион байгуулсан ЭМГ-ын хүний нөөцийн мэргэжилтний хуулийн сургалт Улаанбаатар хотод мэргэжилтэн Р.Мөнхбаясгаланг хамруулсан.</p> <p>ЭМЯ, ЭМХТөвтэй хамтран зохион байгуулсан “Хууль эрх зүй, хүний эрх” зайн сургалтанд 5 албан хаагч хамрагдсан.</p> <p>Аймгийн төвд зохион байгуулагдсан “Анагаах ухааны эрх зүй” 1 өдрийн сургалтанд ЭТХ-ийн дарга Л.Ганбат хамрагдсан байна. <b>Үр дүн:</b> Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн.</p> <p><b>Үр дүн:</b> Албан хаагчдын ёс зүй болон хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн.</p>	70
<b>5. Ажилчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх чиглэлээр</b>			
20	Рашаан сувилалд хөнгөлөлттэй хамруулах, хамруулах ажлыг зохион байгуулах	ЭМГ-ын няравыг Хужирт рашаан сувилалд хөнгөлөлттэй хамруулсан.	40
21	Ажигчдыг байгалийн үзэсгэлэнт газруудаар тойрон аялалаар явуулах, тэдний хооронд ажил мэргэшлийн аварга шалгаруулах уралдаан, урлаг спортын тэмцээн тогтмол зохиож байх	<p>Дорнод аймагт 2018 оны 06 дугаар сарын 04-05 ны өдрүүдэд болох төв болон зүүн бүсийн аймгуудын Эрүүл мэндийн газруудын төрийн албан хаагчдын дунд зохион байгуулагдах “Спортын нөхөрсөг тэмцээн”-д 15 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид явж 4 төрөл тэмцээнд оролцож, Дорнод аймаг ЭМГазрын туршлага судлаж, байгалийн үзэсгэлэнт газруудаар явсан.</p> <p>Гурвансайхан суманд байдаг Их газрын чулууны үзэсгэлэнт газраар 8 сард “Эмнэлгийн ажилчдын байр”-аар бүх ажилчдыг 3 хоног аялуулсан.</p>	100

22	Ажилтнуудыг жил тутам эрүүл мэндийн сорилд хамруулж, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх арга хэмжээ авах	<p>Монгол улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 53 дугаар зарлиг, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, Монгол улсын "Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ" 2005:5538 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын сарын аяныг 4 сарын 2-ноос 4 сарын 30 хугацаанд зохион байгуулж явууллаа.</p> <p>Эрүүл мэндийн газрын нийт 26 ажилтан сорилд хамрагдахаас 22 хүн хамрагдаж үнэлгээг гаргаж хүн тус бүрт зөвлөгөөг өгсөн. Үнэлгээгээр А үнэлгээтэй 9, В үнэлгээтэй 7, С үнэлгээтэй 4, D үнэлгээтэй 2 албан хаагч байлаа.</p>	70
<b>Хэрэгжилт</b>		<b>81.8</b>	

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛ, ХАНГАЛТ, МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВШӨӨРӨЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТӨН: Р.МӨНХБАЯСГАЛАН

ХЯНАСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Б.БАТ-ОРШИХ

